

1. БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ (2026.II улирлын тайлан)

(2026 оны II улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн:

Банкуудаас 2026 оны 7 дугаар сард санал асуулга хэлбэрээр өнгөрсөн болон ирэх 3 сарын хугацааны зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулж, нэгтгэсэн тайланг боловсруулав. Мөн энэ улирлаас асуулга болон үр дүнг нэгтгэн тооцох аргачлалд зарим шинэчлэл¹ оруулав.

Банкны зээлийн төлөвийн судалгааны онцлог:

- Зээлийн нийлүүлэлтийн нөхцөл, зээлийн эрэлт болон тэдгээрийн өөрчлөлтийн шалтгааныг банкуудын **үнэлгээнд тулгуурлан тодорхойлдог чанарын** судалгаа.
- **Өнгөрсөн 3 сарын өөрчлөлт болон ирэх 3 сарын хүлээлтийг зэрэг үнэлдэг тул зээлийн үлдэгдэл, өсөлт, хүү зэрэг үзүүлэлтүүдийн түүхэн өөрчлөлтийг шинжлэхэд нэмэлт чанарын мэдээлэл болохын зэрэгцээ зээлийн ирээдүйн төлөвийг тодорхойлоход ашиглагдах мэдээлэл² болдог.**
- Зээлийн зах зээлийн өөрчлөлт банкны **зээл олголтын бодлогоос уу, эсвэл зээлдэгчийн санхүүжилтийн хэрэгцээнээс үү гэдгийг** ялган үнэлэх боломж олгодог.
- Зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт болон тэдгээрт нөлөөлөх эрсдэл, эх үүсвэрийн зардал, өрсөлдөөн, санхүүжилтийн хэрэгцээ зэрэг хүчин зүйлсийг нарийвчлан үнэлдэг.

Зээлийн шалгуур:

Өнгөрсөн улиралд банкууд:

- ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулжээ. Дунд банкууд том болон жижиг банкуудаас илүүтэй сулруулсан байна.
- Иргэдийн зээлийн шалгуураа мөн бага зэрэг сулруулав. Том банкууд хамгийн өндөр индексийн утгаар иргэдийн зээлийн шалгуурыг сулруулсан бол жижиг банкууд бага зэрэг чангаруулжээ.

Ирэх улиралд банкууд:

- ААН-ийн зээлийн шалгуураа үргэлжлүүлэн бага зэрэг сулруулах төлөвтэй. Үүнд жижиг болон дунд банкууд том банкуудаас илүүтэйгээр зээлийн шалгуурыг сулруулах хүлээлттэй байна.
- Иргэдийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах хүлээлт давамгайллаа. Жижиг банкууд зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулах дүр зурагтай бол том болон дунд банкууд зээлийн шалгуурыг хэвээр хадгалах төлөв түүвэр судалгааны үр дүнгээр гарав.

¹ Шинэчлэлийн хүрээнд аж ахуйн нэгжийн салбар болон иргэдийн зээлийн төрлөөр жигнэсэн дэд индексүүдийг нэмж тооцох, ирэх 3 сарын төлөвийг салбар, зээлийн төрөл болон дэд үзүүлэлтийн задаргаагаар авах, аж ахуйн нэгж болон иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөх хүчин зүйлсэд “цахим шилжилт, зээлийн бүтээгдэхүүний өрсөлдөөн” үзүүлэлтийг, мөн иргэдийн зээлийн нөхцөлийн хэсэгт “зээл-үнэлгээний харьцаа (LTV)” болон “зээлийн дүнгийн бусад хязгаарлалт” үзүүлэлтүүдийг тус тус шинээр нэмсэн.

² Тухайлбал (Tigran, 2025/262) нарын “[Changes in Bank Lending Standards and the Macroeconomy: Evidence from Mongolia](#)” судалгаанд “Банкны зээлийн төлөвийн судалгаа”-ны зээлийн шалгуурын үзүүлэлтийг банкны зээлийн нийлүүлэлтийн шокийг илэрхийлэх хувьсагч болгон ашигласан байдаг. Тус судалгаагаар банкны зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нөлөөг салгаж, цэвэр нийлүүлэлтийн шокийг тодорхойлсноороо онцлог юм. Мөн түүнчлэн “Банкны зээлийн төлөвийн судалгаа”-ны 2026 оны I улирлын тайланд судалгааны үр дүн бодит гүйцэтгэлтэй хэр нийцтэй байгааг үнэлэх зорилгоор судалгааны хариултуудыг зээлийн статистик мэдээлэлтэй харьцуулсан. Үр дүнгээр, банкууд зээлийн шалгуур болон бусад нөхцөлөө чангаруулсан гэж мэдээлсэн үед зээлийн өсөлт саарах, зээлийн хүүний нөхцөлийг чангаруулсан үед бодит зээлийн жигнэсэн дундаж хүү өсөх, зээлийн хугацааны нөхцөлийг чангаруулсан үед шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа буурах зэрэг хандлага ажиглагдсан нь тус судалгааны асуулгын хариултууд банкны зээлийн бодлого, нөхцөлд гарч буй өөрчлөлтийн ерөнхий чиг хандлагыг бодит статистик мэдээлэлтэй нийцтэй тусгаж буйг харуулжээ.

Зээлийн шалгуур - Банк зээл олгох эсэхийг шийдвэрлэхдээ баримталдаг дотоод бодлого, зээлдэгчийг сонгох болон зээлийн хүсэлтийг зөвшөөрөх үндсэн шалгуур, шаардлагын түвшнийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, зээлийн шалгуур нь банкнаас зээл олгох шийдвэр гаргахын өмнө тогтоосон зээлдэгчийн болон зээлийн хүсэлтийн үнэлгээний босго бөгөөд тухайн босго хэр зэрэг чангарсан, эсхүл суларсныг харуулна.

Зээлийн нөхцөл:

- Өнгөрсөн улиралд банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулжээ. Том банкууд илүүтэй сулруулсан бол жижиг банкууд бага зэрэг чангаруулсан байна. Харин иргэдийн зээлийн нөхцөлөө хэвээр хадгалсан байна.
- Ирэх улиралд банкууд ААН-ийн болон иргэдийн зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах хүлээлттэй байна.

Зээлийн нөхцөл — Банкнаас зөвшөөрсөн зээлийг зээлдэгчид ямар нөхцөлөөр олгож байгааг илэрхийлнэ. Үүнд зээлийн хүүгийн маржин, зээлийн хэмжээ, хугацаа, барьцааны шаардлага, шимтгэл, зээл-үнэлгээний харьцаа болон зээлийн гэрээний бусад нөхцөл хамаарна. Өөрөөр хэлбэл, зээлийн нөхцөл нь зээл олгох шийдвэр гарсны дараа тухайн зээлдэгчтэй бодитоор тохиролцсон гэрээний нөхцөл хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулна.

Зээлийн эрэлт:

Өнгөрсөн улиралд:

- ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг өсжээ. Том болон дунд банкуудад ойролцоо түвшинд нэмэгдсэн бол жижиг банкуудад зээлийн эрэлт харьцангуй бага түвшинд нэмэгдэв.
- Иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг эрчимжлээ. Том болон дунд банкуудад ойролцоо түвшинд нэмэгдсэн бол жижиг банкуудад харьцангуй бага хэмжээгээр нэмэгдсэн байна.

Ирэх улиралд:

- ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэх, үүн дотроо жижиг банкуудын хувьд илүүтэй, том болон дунд банкуудын хувьд харьцангуй бага түвшинд нэмэгдэх хүлээлттэй байна.
- Иргэдийн зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй. Том болон жижиг банкуудын хувьд зээлийн эрэлт харьцангуй өндөр түвшинд, дунд банкуудын хувьд арай бага хэмжээгээр нэмэгдэх төлөв түүвэр судалгааны үр дүнгээр гарлаа.

Зээлийн эрэлт — Аж ахуйн нэгж, иргэдийн банкны зээлээр санхүүжих хэрэгцээ, хүсэл хэрхэн өөрчлөгдөж байгааг илэрхийлнэ. Энэ нь зөвхөн бодитоор олгогдсон зээлийн хэмжээг бус, шинэ зээл авах болон банкны санхүүжилт ашиглах хэрэгцээ, сонирхлын ерөнхий өөрчлөлтийг хамарна. Зээлийн эрэлтийг банкны зээл олгох бодлого, шалгуур болон нөхцөлөөс тусад нь авч үздэг.

Зээлийн нийлүүлэлт:

Ирэх улиралд банкууд:

- ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг өсгөх, үүнд том, дунд болон жижиг банкны нийт ангилалд харьцангуй ижил түвшинд нэмэгдүүлэх хүлээлттэй байна.
- Иргэдийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг өсгөх хандлагатай бөгөөд жижиг болон том банкууд дунд банкуудаас илүүтэй нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Зээлийн нийлүүлэлт — Банкны ирэх хугацаанд зээл олголтын хэмжээг нэмэгдүүлэх, хэвээр хадгалах, эсхүл бууруулах төлөв, чиг хандлагыг илэрхийлнэ. Энэхүү үзүүлэлт нь банкны зээл олгох сонирхол, санхүүгийн боломж болон эрсдэлийн үнэлгээнд үндэслэн зах зээлд нийлүүлэх зээлийн хэмжээ цаашид хэрхэн өөрчлөгдөх хүлээлтийг харуулна.

Хүснэгт 1. Судалгааны хураангуй үр дүн

Банкууд	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт		Зээлийн нийлүүлэлт	
	ААН	Иргэн	ААН	Иргэн	ААН	Иргэн	ААН	Иргэн
<i>Өмнөх улирлын</i>								
Нийт								
Жижиг банкууд								
Дунд банкууд								
Том банкууд								
<i>Ирэх улирлын</i>								
Нийт								
Жижиг банкууд								
Дунд банкууд								
Том банкууд								


**Тайлбар: Зээлийн шалгуур болон зээлийн нөхцөлийн хувьд улаан өнгө нь чангарсан, ногоон өнгө нь суларсан чиглэлийг илэрхийлнэ. Харин зээлийн эрэлт болон зээлийн нийлүүлэлтийн хувьд ногоон өнгө нь өссөн, улаан өнгө нь буурсан чиглэлийг илэрхийлнэ.*

I. Зээлийн шалгуур

1.1. Аж ахуйн нэгжийн зээлийн шалгуур


2026 оны II улиралд ААН-ийн зээлийн шалгуурын индекс -0.09 утгатай гарч, банкууд зээлийн шалгуураа бага зэрэг бууруулсан байна. Өмнөх улиралд банкууд энэ улирлын зээлийн шалгуурыг бага зэрэг бууруулна хэмээн хүлээж байсантай чиглэлийн хувьд нийцтэй байна. Аж ахуйн нэгжийн зээлийн шалгуурыг сулруулахад нийт эрсдэл /үүнд эдийн засгийн нөхцөл байдал, тухайн салбарын төлөв байдал, барьцаа хөрөнгийн эрсдэл/ болон эх үүсвэрийн зардал буурч, эрсдэл даах чадвар нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 1).

Зураг 1. ААН-ийн зээлийн шалгуурын индекс, нөлөөлөгч хүчин зүйлсээр



Энэхүү ААН-ийн зээлийн шалгуурын өөрчлөлтийг зээл олгогдсон салбарын ангиллаар авч үзвэл банкууд худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн шалгуураа сулруулж, харин бусад салбарт олгосон зээлийн шалгууртаа төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна. Өөрөөр хэлбэл энэ салбарт олгосон зээлийн шалгуурын өөрчлөлтийн нөлөө нь нийт ерөнхий индексийн бууралтыг тайлбарлаж байна. Мөн өнгөрсөн хугацааны ерөнхий зураглалыг харвал ААН-ийн зээлийн шалгуурын индекс сулрах мужид ихэвчлэн гарч, тэр бүр нь худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн шалгуурын бууралтаар давамгайлан тайлбарлагдаж байна (Зураг 2).


Зураг 2. ААН-ийн зээлийн шалгуурын индекс, салбараар



Банкууд ирэх улиралд ААН-д олгох зээлийн шалгуураа бага зэрэг сулруулах төлөвтэй байна. Зээлийн шалгуурын төлөвийг салбарын ангиллаар нь авч үзвэл боловсруулах салбарын зээлийн


шалгуурын бууралт нийт бууралтын ихэнх хэсгийг тайлбарлаж байгаа бол худалдаа, үйлчилгээ болон ХАА-н салбарын зээлийн шалгуурын бууралт бага зэрэг нөлөөтэй байна. Ерөнхий зураглалыг харвал зээлийн шалгуурын төлөвийн үзүүлэлт 2023 оны I улирлаас хойш ихэвчлэн 0-ээс доош утгатай буюу сулрах мужид гарч байна. Энэхүү ирэх 3 сарын “төлөвийн” үзүүлэлтийг өнгөрсөн 3 сарын хугацаан дахь “бодит” үзүүлэлттэй харьцуулахад ихэнх улиралд нийцтэй дүр зураг гарчээ (Зураг 3).

Зураг 3. ААН-ийн зээлийн шалгуурын төлөв, салбараар



ААН-ийн зээлийн шалгуурын төлөвийг банкны хэмжээгээр авч үзвэл ирэх улиралд жижиг болон дунд банкууд том банкуудаас илүүтэйгээр зээлийн шалгуурыг сулруулах хүлээлттэй байна. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал дунд банкууд ихэнх хугацаанд 0 – ээс дээш утгатай буюу шалгуурыг чангаруулах мужид илүү давамгайл хариулт өгсөн бол том банкууд ихэнх хугацаанд шалгуурыг сулруулах мужид давамгайл хариулт өгсөн байна. Харин жижиг банкуудын хувьд сүүлийн 7 улирал дараалан зээлийн шалгуурын төлөвийг бага зэрэг сулруулах мужид, харьцангуй тогтвортой индексийн үзүүлэлттэйгээр хадгалжээ (Зураг 4).


Зураг 4. ААН-ийн зээлийн шалгуурын төлөв, банкуудын хэмжээний ангиллаар



1.2. Иргэдийн зээлийн шалгуур


2026 оны II улиралд иргэдийн зээлийн шалгуурын индекс - 0.08 утгатай гарсан бөгөөд энэ хугацаанд банкууд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулжээ. Энэ нь өмнөх улиралд банкууд иргэдийн зээлийн шалгуурын төлөвийг бага зэрэг /өмнөх улирлын хүлээлтийн индексийн утга: - 0.04/ сулруулна гэж хүлээж байсантай чиглэлийн хувьд нийцтэй гарсан үзүүлэлт юм. Нийт эрсдэл /үүнд эдийн засгийн нөхцөл байдал, харилцагчийн төлбөрийн чадвар болон барьцаа хөрөнгийн эрсдэл/ болон эх үүсвэрийн зардал буурсан зэрэг нь голлон нөлөөлжээ (Зураг 5).

Зураг 5. Иргэдийн зээлийн шалгуурын индекс, нөлөөлөгч хүчин зүйлсээр




Иргэдийн зээлийн шалгуурын өөрчлөлтийг зээлийн төрлөөр нь авч үзвэл банкууд 2026 оны II улиралд иргэдэд олгосон бизнесийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан нь индексийн бууралтыг голлон тайлбарлаж байна. Өмнөх улирлын хүлээлтийг зээлийн төрлөөр авч үзэхэд банкууд тэтгэврийн зээлийн шалгуурыг сулруулах нь индексийн бууралтыг голлон тайлбарлана гэж хүлээж байжээ (Зураг 6).

Зураг 6. Иргэдийн зээлийн шалгуурын индекс, зээлийн төрлөөр




Банкуудын өмнөх улирлын хүлээлтээр энэ улиралд иргэдийн зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулах төлөвтэй байсан бол ирэх улиралд иргэдийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 7).

Зураг 7. Иргэдийн зээлийн шалгуурын төлөв, зээлийн төрлөөр



Иргэдийн зээлийн шалгуурын төлөвийг банкны хэмжээгээр авч үзвэл ирэх улиралд жижиг банкууд зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулах дүр зурагтай, харин том болон дунд банкууд зээлийн шалгуурыг хэвээр хадгалах төлөвтэй харагдаж байна. Өнгөрсөн хугацааны ерөнхий зураглалыг харвал том, дунд, жижиг банкууд иргэдийн зээлийн хувьд зээлийн шалгуурыг чангаруулах, сулруулах мужийн хооронд давтамж өндөртэй шилжсэн байна. Энэ нь өмнөх бүлэгт харуулсан ААН-үүдийн зээлийн шалгуурыг банкны хэмжээгээр ангилсан үзүүлэлттэй харьцуулахад хэлбэлзэл өндөртэй буюу банкууд иргэдэд олгох зээлийн шалгуурыг илүүтэй өөрчлөх хандлагатайг харуулж байна (Зураг 8).

Зураг 8. Иргэдийн зээлийн шалгуурын төлөв, банкуудын хэмжээний ангиллаар




II. Зээлийн нөхцөл

2.1. Аж ахуйн нэгжийн зээлийн нөхцөл


2026 оны II улиралд банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулжээ. Өмнөх улиралд банкууд ААН-ийн зээлийн нөхцөлийн төлөвийг бага зэрэг чангаруулах /өмнөх улирлын хүлээлтийн индексийн утга: 0.03/ хүлээлттэй байсан ч энэ улирлын үр дүнгээр сулруулсан чиглэлд гаржээ. Үүнд нөлөөлсөн хүчил зүйлээр нь авч үзвэл өрсөлдөөн зээлийн ерөнхий нөхцөлийг чангаруулах чиглэлд, эх үүсвэрийн зардал болон эрсдэл буурч, эрсдэл даах чадвар нэмэгдсэн нь сулруулах чиглэлд нөлөөлөв. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал ААН-ийн зээлийн нөхцөлийг чангаруулсан тохиолдлуудад ихэвчлэн эх үүсвэрийн зардал болон эрсдэл нэмэгдсэнтэй холбоотой байсан бол зээлийн нөхцөлийг сулруулсан тохиолдолд ихэвчлэн өрсөлдөөн нэмэгдсэнтэй холбоотой байсан дүр зураг гарчээ (Зураг 9).

Зураг 9. ААН-ийн зээлийн нөхцөлийн индекс, нөлөөлөгч хүчин зүйлсээр




Банкуудаас ААН-д олгосон зээлийн нөхцөлийн тухай ерөнхий үзүүлэлтээс гадна дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан асуухад 2026 оны II улиралд зээлийн хүү болон хүүний бус шимтгэл, хураамжийг нэмэгдүүлсэн нь банкуудын зээлийн ерөнхий нөхцөлийн индексийг чангаруулах чиглэлд, зээлийн хэмжээг ихэсгэх, хугацааг уртасгах, барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах нь тус индексийг сулруулах чиглэлд нөлөөлснөөр ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл сулрах мужид байна. Зээлийн нөхцөлийн дэд үзүүлэлтүүдийн онцлогоос харахад зээлийн хүү өсөх нь зээлийн нөхцөлийн ерөнхий индексийг чангаруулах чиглэлд ихэвчлэн нөлөөлсөн бол барьцаа хөрөнгийн шаардлагыг багасгах болон зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг нь зээлийн нөхцөлийн ерөнхий индексийг сулруулах чиглэлд ихэвчлэн нөлөөлсөн дүр зураг ажиглагдлаа (Зураг 10).

Зураг 10. ААН-ийн зээлийн нөхцөлийн индекс, дэд үзүүлэлтээр




ААН-ийн зээлийн нөхцөлийг салбараар авч үзвэл 2026 оны II улиралд банкууд барилгын салбарт олгосон зээлийн нөхцөлөө бага зэрэг, худалдаа, үйлчилгээний салбарт давамгайлан сулруулсан байна. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал 2022 оны эхэн үеэс 2023 оны сүүл хүртэл банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө чангаруулах хандлагатай байсан ба энэ нь худалдаа, үйлчилгээний салбарт давамгай илэрч байжээ. Харин 2024 оны эхэн үеэс зээлийн шалгуурын нөхцөлийг харьцангуй тогтвортой, бага зэрэг бууруулсан хандлагатай байсан бөгөөд энэ нь мөн л худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн нөхцөлд давамгайлан илэрсэн байна (Зураг 11).

Зураг 11. ААН-ийн зээлийн нөхцөлийн индекс, салбараар




Банкууд ирэх улиралд ААН-д олгох зээлийн ерөнхий нөхцөлөө хэвээр хадгалах төлөвтэй байна. Зээлийн нөхцөлийн дэд үзүүлэлтүүдээр авч үзвэл зээлийн хэмжээг нэмэгдүүлэх нь зээлийн нөхцөлийг сулруулах чиглэлд нөлөөлөх боловч зээлийн хүүг өсгөх нь чангаруулах чиглэлд нөлөөлөх төлөвтэй байна (Зураг 12).

Зураг 12. ААН-ийн зээлийн нөхцөлийн төлөв, дэд үзүүлэлтээр



ААН-ийн зээлийн нөхцөлийн төлөвийг банкны хэмжээгээр авч үзэхэд ирэх улиралд нийт банкууд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах төлөвтэй байна. Өнгөрсөн хугацааны хандлагыг харвал ААН-ийн зээлийн нөхцөлийн төлөвийн индекс дийлэнх хугацаанд чангаруулах мужид байсан бөгөөд ялангуяа том банкуудын хувьд дунд болон жижиг банкуудтай харьцуулахад илүү олон давтамжтайгаар чангаруулах мужид гарчээ (Зураг 13).


Зураг 13. ААН-ийн зээлийн нөхцөлийн төлөв, банкуудын хэмжээний ангиллаар



2.2. Иргэдийн зээлийн нөхцөл


2026 оны II улиралд иргэдийн зээлийн нөхцөлийн ерөнхий индекс -0.01 утгатай гарч банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө хэвээр хадгалсан байна. Өмнөх улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлийн төлөвийг бага зэрэг чангаруулна /өмнөх улирлын хүлээлтийн индексийн утга: 0.03/ гэж хүлээж байв. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал банкууд иргэдэд олгосон зээлийн нөхцөлөө ихэвчлэн хэвтээ тэнхлэгтэй ойролцоо буюу бараг өөрчлөлтгүй мужид хадгалж ирсэн байна. Харин 2024 оны сүүл болон 2025 оны эхээр нийт эрсдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэдийн зээлийн нөхцөлийг багагүй чангаруулах нөхцөл үүссэн хэдий ч өрсөлдөөн болон банкны өөрийн эрсдэл даах чадвар өндөр байсантай холбоотойгоор зээлийн нөхцөлийн индексийг тэнцвэржүүлэн өөрчлөлтгүй мужид хадгалжээ (Зураг 14).

Зураг 14. Иргэдийн зээлийн нөхцөлийн индекс, нөлөөлөгч хүчин зүйлсээр




Банкуудаас иргэдэд олгосон зээлийн нөхцөлийн тухай ерөнхий үзүүлэлтээс гадна дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан асуухад 2026 оны II улиралд банкуудын иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэх, хугацаа уртсах нөлөө байгаа боловч энэ нь ерөнхий индексийн хөдөлгөөнтэй уялдуулан авч үзвэл маш бага хэмжээгээр нөлөөлсөн буюу ерөнхий индексийн утга төдийлөн өөрчлөлтгүй гарч иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл хэвээр хадгалагджээ. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал зээлийн нөхцөлийн дэд үзүүлэлт дундаас зээлийн хэмжээний өөрчлөлт нь иргэдийн зээлийн нөхцөлийн ерөнхий индексийн хөдөлгөөний ихэнх хэсгийг тайлбарлаж байна (Зураг 15).

Зураг 15. Иргэдийн зээлийн нөхцөлийн индекс, дэд үзүүлэлтээр




Иргэдийн зээлийн нөхцөлийг зээлийн төрлөөр авч үзвэл 2026 оны II улиралд банкууд иргэдэд олгох бизнесийн болон малчны зээлийн нөхцөлийг маш бага индексийн утгаар сулруулжээ. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал 2022 оны иргэдийн зээлийн нөхцөлийг чангаруулж байсан хугацаанд бизнесийн зээлийн төрөлд илүүтэй чангаруулах нөлөөтэй байсан бол түүнээс хойш зээлийн нөхцөлийг сулруулсан хугацаанд мөн адил бизнесийн зээлийн төрөлд бусад зээлийн төрөлтэй харьцуулахад илүү давамгайлан сулруулж байсан дүр зурагтай байна (Зураг 16).

Зураг 16. Иргэдийн зээлийн нөхцөлийн индекс, зээлийн төрлөөр




Банкуудын ирэх улиралд иргэдэд олгох зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 17).

Зураг 17. Иргэдийн зээлийн нөхцөлийн төлөв, дэд үзүүлэлтээр



Иргэдийн зээлийн нөхцөлийн төлөвийг банкны хэмжээгээр авч үзвэл ирэх улиралд дунд банкууд зээлийн нөхцөлөө үл ялиг чангаруулах төлөвтэй байгаа бол том болон жижиг банкуудын хувьд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 18).

Зураг 18. Иргэдийн зээлийн нөхцөлийн төлөв, банкуудын хэмжээний ангиллаар




III. Зээлийн эрэлт

3.1. Аж ахуйн нэгжийн зээлийн эрэлт


2026 оны II улиралд ААН-ийн зээлийн эрэлтийн индекс 0.34 утгатай гарч ААН-ийн зээлийн эрэлт нэмэгджээ. Энэ нь банкууд өмнөх улиралд ААН-ийн зээлийн эрэлтийн төлөвийг /өмнөх улирлын хүлээлтийн индексийн утга: 0.47/ нэмэгдэнэ гэж хүлээж байсан үр дүнтэй нийцтэй байна. Ийнхүү зээлийн эрэлт өсөхөд ААН-үүдийн үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх хэрэгцээ голлон нөлөөлж санхүүгийн бусад хэрэгцээ болон хүүний түвшин мөн тодорхой хэмжээнд нөлөөлөв (Зураг 19).

Зураг 19. ААН-ийн зээлийн эрэлтийн индекс, нөлөөлөгч хүчин зүйлсээр




ААН-ийн зээлийн эрэлтийг салбараар ангилан авч үзвэл 2026 оны II улиралд ААН-ийн бүх салбаруудад зээлийн эрэлт нэмэгдсэн, тэр дундаа худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлт хамгийн их хэмжээгээр өссөн буюу нийт өсөлтийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа бол боловсруулах, барилга болон уул уурхайн салбарт зээлийн эрэлт ойролцоо хэмжээгээр нэмэгдсэн дүр зурагтай байна. Энэ нь өмнөх улирлын хүлээлтийн индексийг салбараар задалсан бүтэцтэй нийцтэй байгаа боловч худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлтийн өсөлтийн эрч хүлээлтээс бага зэрэг саарсан байна. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал ААН-ийн зээлийн эрэлтийн өсөлтийг худалдаа, үйлчилгээний салбар ихээхэн өдөөсөн байна (Зураг 20Зураг 15).

Зураг 20. ААН-ийн зээлийн эрэлтийн индекс, салбараар




ААН-ийн зээлийн эрэлтийн төлөвийн индекс 0.08 утгатай гарч ирэх улиралд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэх боловч өсөлтийн эрч мэдэгдэхүйц буурах төлөвтэй гарлаа. ААН-ийн зээлийн салбарын ангиллаар авч үзвэл худалдаа, үйлчилгээний салбарт бага зэрэг нэмэгдэх төлөвтэй байна. Энэхүү худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлт нийт эрэлтийн төлөвт давамгайлан нөлөөлж буй дүр зураг зөвхөн энэ улиралд биш нийт өнгөрсөн хугацаанд давтагдсан хандлага болж байна (Зураг 21).

Зураг 21. ААН-ийн зээлийн эрэлтийн төлөв, салбараар



Ирэх улирлын ААН-ийн зээлийн эрэлтийн төлөвийн үзүүлэлтийг банкны хэмжээгээр авч үзвэл том болон дунд банкуудын хувьд ААН-ийн зээлийн эрэлтийн индекс буурсан бол жижиг банкуудын хувьд өмнөх улирлын индекс тэй ойролцоо түвшинд гарсан байна. Үүний нөлөөгөөр зээлийн эрэлтийн төлөвийн ерөнхий индекс өмнөх улиралтай харьцуулахад багагүй буурсан хэдий ч зээлийн эрэлт нэмэгдэх мужид байна (Зураг 22).


Зураг 22. ААН-ийн зээлийн эрэлтийн төлөв, банкуудын хэмжээний ангиллаар



3.2. Иргэдийн зээлийн эрэлт


2026 оны II улиралд иргэдийн зээлийн эрэлтийн индекс 0.22 утгатай гарч иргэдийн зээлийн эрэлт нэмэгджээ. Энэ нь банкууд өмнөх улиралд иргэдийн зээлийн эрэлтийн төлөвийг /өмнөх улирлын хүлээлтийн индексийн утга: 0.31/ нэмэгдэнэ гэж хүлээж байсан үр дүнтэй чиглэлийн хувьд нийцтэй ч өсөлтийн эрч бага зэрэг суларсан үзүүлэлт болж байна. Ийнхүү иргэдийн зээлийн эрэлт өсөхөд хэрэглэгчийн итгэл сайжирсан, иргэдийн удаан эдэлгээт бараа авах болон бусад санхүүгийн хэрэгцээ өссөн зэрэг нь голлон нөлөөлжээ. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийн ерөнхий хандлагыг харвал хэрэглэгчийн итгэл сайжрах нь зээлийн эрэлтийг өсгөх үндсэн шалтгаан болдог байна (Зураг 23).

Зураг 23. Иргэдийн зээлийн эрэлтийн индекс, нөлөөлөгч хүчин зүйлсээр




Иргэдийн зээлийн эрэлтийг зээлийн төрлөөр нь авч үзвэл, 2026 оны II улиралд цалингийн зээлийн эрэлт хамгийн өндөр байсан бөгөөд иргэдэд олгосон бизнесийн зээлийн эрэлт ойролцоо түвшинд удаалж, нийт өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлжээ. Харин тэтгэвэр болон малчны зээлийн эрэлт харьцангуй бага хэмжээгээр нэмэгдсэн бөгөөд уг өсөлт нь өмнөх улирлын төлөвийн индексэд туссан хүлээлттэй харьцуулахад сул байв. Ийнхүү иргэдийн зээлийн эрэлтийн ерөнхий индекс өсөлтийн мужид хадгалагдсан байна. Өмнөх улиралд иргэдийн зээлийн эрэлтийн төлөвийг зээлийн төрлөөр авч үзэхэд иргэдэд олгох бизнесийн зээлийн эрэлт хамгийн өндөр өсөх, цалингийн зээл үүний дараа орох, харин тэтгэвэр болон малчны зээлийн эрэлт ойролцоо түвшинд бага зэрэг нэмэгдэх хүлээлттэй байжээ (Зураг 24).

Зураг 24. Иргэдийн зээлийн эрэлтийн индекс, зээлийн төрлөөр




Иргэдийн зээлийн эрэлтийн төлөвийн индекс 0.29 утгатай гарч ирэх улиралд зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй гарлаа. Уг үзүүлэлт өмнөх улирлын төлөвийн индексстэй ойролцоо түвшинд байгаа бөгөөд иргэдийн зээлийн эрэлтийн төлөв сүүлийн таван улиралд ойролцоо түвшинд өсөх хүлээлттэй байв. Иргэдийн зээлийн төрлөөр авч үзвэл нийт төрөлд зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй, ялангуяа цалин болон тэтгэврийн зээлийн эрэлт нийт өсөлтийн дийлэнх хэсгийг эзэлж, бусад зээлийн төрлөөс өндөр байхаар байна (Зураг 25).

Зураг 25. Иргэдийн зээлийн эрэлтийн төлөв, зээлийн төрлөөр



Ирэх улирлын иргэдийн зээлийн эрэлтийн төлөвийн үзүүлэлтийг банкны хэмжээгээр авч үзвэл дунд банкуудын хувьд харьцангуй бага түвшинд, том болон жижиг банкуудын хувьд илүү түвшинд зээлийн эрэлт нэмэгдэх хүлээлттэй байна. Энэхүү эрэлтийн хүлээлтийн утгыг банкуудын өмнөх улирлын хүлээлттэй харьцуулахад дунд банкуудын хувьд хэвэндээ, жижиг банкуудын хувьд буурсан, харин том банкуудын хувьд өссөн үзүүлэлттэй байна (Зураг 26).

Зураг 26. Иргэдийн зээлийн эрэлтийн төлөв, банкуудын хэмжээний ангиллаар




IV. Зээлийн нийлүүлэлт

4.1. Аж ахуйн нэгжийн зээлийн нийлүүлэлт


Банкуудын ирэх улиралд ААН-д олгох зээлийн нийлүүлэлтийн өөрчлөлтийн индекс 0.19 утгатай гарч банкууд ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй гарсан ч өмнөх улирлын үзүүлэлттэй харьцуулахад мэдэгдэхүйц эрч нь саарсан байна. ААН-ийн салбараар харвал нийт салбарт зээл олголтыг нэмэгдүүлэх, ялангуяа худалдаа, үйлчилгээний салбарт түлхүү нэмэгдүүлэх, харин барилга, боловсруулах болон уул уурхайн салбаруудад харьцангуй бага нэмэгдүүлэх төлөвтэй байна. Өмнөх улирлын төлөвтэй харьцуулахад энэ нь худалдаа, үйлчилгээний салбарт эрч ихээхсэн саарсан, барилгын салбарт бага зэрэг саарсан үзүүлэлт бол боловсруулах болон уул уурхайн салбарын хэвээр үлджээ. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал 2023 оны эхэн үеэс банкуудын ААН-д олгох зээлийн төлөв нэмэгдэх мужид байж ирсэн ба худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нөлөө нь зээлийн нийлүүлэлтийн ерөнхий индексийн утгыг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөөтэй байжээ (Зураг 27).

Зураг 27. ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөв, салбараар



ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөвийг банкны хэмжээгээр авч үзвэл том, дунд болон жижиг банкны нийт ангилалд ижил түвшинд зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлттэй байна (Зураг 28).


Зураг 28. ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөв, банкуудын хэмжээний ангиллаар



4.2. Иргэдийн зээлийн нийлүүлэлт

Банкуудын ирэх улиралд иргэдэд олгох зээлийн нийлүүлэлтийн өөрчлөлтийн индекс 0.19 утгатай гарч банкууд иргэдийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй гарсан ч өмнөх улиралтай харьцуулахад мэдэгдэхүйц эрч нь саарсан байна. Ийнхүү индекс буурахад бизнесийн зээлийн өөрчлөлт голлон нөлөөлж байна. Банкууд ирэх улиралд цалингийн зээлийн нийлүүлэлтийг бусад төрлийн зээлээс илүүтэй нэмэгдүүлэх /энэ нь дангаар ерөнхий индексийн өсөлтийн талаас илүү хувийг эзэлж байна/, иргэдэд олгох бизнесийн зээл, тэтгэвэр болон малчны зээлийн олголтыг бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Өнгөрсөн хугацааны ерөнхий хандлагыг харвал банкууд иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөвийг нэмэгдүүлэх, тэр дундаа цалин болон иргэдийн бизнесийн зээлийн төрөлд нэмэгдүүлэх төлөв бүх цаг хугацаанд зонхилжээ (Зураг 29).


Зураг 29. Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөв, зээлийн төрлөөр



*- Ипотекийн зээлийн дүнг оруулаагүй болно.

Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөвийг банкны хэмжээгээр авч үзвэл нийт банкууд иргэдийн зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй ч өмнөх улирлын хүлээлтийн утгатай харьцуулвал том банкуудын хувьд өмнөх улирлын хүлээлтийн утгаас багагүй буурсан, дунд банкуудын хувьд бага зэрэг буурсан, жижиг банкуудын хувьд бага зэрэг нэмэгдсэн үзүүлэлт болж байна (Зураг 30).

Зураг 30. Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөв, банкуудын хэмжээний ангиллаар



Хавсралт 1. Арга зүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгааг санал асуулга хэлбэрээр зохион байгуулдаг бөгөөд (i) зээлийн шалгуур, (ii) зээлийн нөхцөл, (iii) зээлийн эрэлт болон (iv) зээлийн нийлүүлэлт гэсэн 4 үндсэн хэсгээс бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын чанарын хариултуудыг нэг утгатайгаар тодорхойлохын тулд тоон утга руу хөрвүүлсэн. Ингэхдээ [-1;+1] хоорондох утгуудад чанарын асуултуудыг Хүснэгт 2-т өгөгдсөн байдлаар индексэд хөрвүүлдэг.

<i>Хүснэгт 2. Индексийн тооцоолол</i>					
Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	<i>Нэлээд суларсан/суларна</i>	<i>Бага зэрэг суларсан/суларна</i>	<i>Өөрчлөгдөөгүй</i>	<i>Бага зэрэг чангарсан/чан гарна</i>	<i>Нэлээд чангарсан/чан гарна</i>
Зээлийн нөхцөл	<i>Нэлээд суларсан/суларна</i>	<i>Бага зэрэг суларсан/суларна</i>	<i>Өөрчлөгдөөгүй</i>	<i>Бага зэрэг чангарсан/чан гарна</i>	<i>Нэлээд чангарсан/чан гарна</i>
Зээлийн эрэлт	<i>Нэлээд багассан/багасна</i>	<i>Бага зэрэг багассан/багасна</i>	<i>Өөрчлөгдөөгүй</i>	<i>Бага зэрэг нэмэгдсэн/нэмэгдэнэ</i>	<i>Нэлээд нэмэгдсэн/нэмэгдэнэ</i>
Зээлийн нийлүүлэлт	<i>Нэлээд бууруулна</i>	<i>Бага зэрэг бууруулна</i>	<i>Өөрчлөхгүй</i>	<i>Бага зэрэг нэмэгдүүлнэ</i>	<i>Нэлээд нэмэгдүүлнэ</i>

Нийт банкны системийн зээлийн төлөвийг тодорхойлохдоо банк тус бүрийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээг тухайн банкны харгалзах индексээр үржүүлэх замаар жигнэсэн дундаж утгыг тооцсон болно. Тухайн хугацаан дахь ерөнхий индексийн утга нь зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх өнгөрсөн 3 сарын байдал болон ирэх 3 сарын төлөвийг илэрхийлнэ.